

**МАЛ ЭМНЭЛЭГИЙН ЭМИЙН СОРИЛТ БАТАЛГААЖУУЛАЛТЫН УЛСЫН ЛАБОРТОРИ  
ТӨААТҮГ-ЫН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТОДРУУЛГАД ХИЙСЭН САНХҮҮГИЙН  
ТАЙЛАНГИЙН АУДИТ**

**Аудитын код:** САГ-2018/238/-СТА-ТӨҮГ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг

Утас: 261663

Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)

Аудитын менежер Я.Самбууням

Утас: 261885

Цахим хаяг: [sambuunyamya@audit.gov.mn](mailto:sambuunyamya@audit.gov.mn)

Аудитор Р.Цолмон

Утас: 261740

Цахим хаяг: [tsolmonr@audit.gov.mn](mailto:tsolmonr@audit.gov.mn)

“Ихмонгол хөлөг Аудит” ХХК-ийн

Захирал С.Тунгалаг

Утас: 70001778

Цахим хаяг: [tungalag.s@imkaudit.mn](mailto:tungalag.s@imkaudit.mn)

Чанарын хяналтын мэргэжилтэн: С.Сождмаа

Утас 70001778

Цахим хаяг: [sojidmaa.s@imkaudit.mn](mailto:sojidmaa.s@imkaudit.mn)

Аудитор: Д.Пүрэвжаргал

Утас: 70001778

Цахим хаяг: [purevjargal.d@imkaudit.mn](mailto:purevjargal.d@imkaudit.mn)

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
**ХЯЗГААРЛАЛТТАЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ**

## АГУУЛГА

---

1	Аудитын гэрчилгээ .....	1
2	Аудитын тайлан.....	3
2.1	Оршил.....	3
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	3
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	4
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	4
2.5	Дотоод хяналт .....	5
2.6	Орлого, зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	5
2.7	Шилэн дансны мэдээлэл .....	5
2.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар .....	5
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл.....	6
2.9.1	<i>Зөвлөмжийн талаар</i> .....	6
2.9.2	<i>Албан шаардлагын талаар</i> .....	6
2.9.3	<i>Актын талаар</i> .....	7
2.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	8
2.11	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд .....	8
2.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл .....	8
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	8
2.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:.....	8
2.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3	Менежментийн захидал .....	9
	Асуудал 1: Бараа материалын талаар .....	10
	Асуудал 2: Авлагын талаар.....	11
	Асуудал 3: Орлогын талаар .....	12
	Асуудал 4: Эзэмшигчийн өмчийн талаар.....	13
4	Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, зорилтот түвшний биелэлт .....	15
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан .....	15
4.2	Аудит хийгдсэн орлогын дэлгэрэнгүй тайлан .....	16
4.3	Аудит хийгдсэн өмчийн өөрчлөлтийн тайлан .....	17
4.4	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	18
4.5	Аудит хийгдсэн зорилтот түвшний биелэлт .....	19

## 1 Аудитын гэрчилгээ

МАЛ ЭМНЭЛЭГИЙН ЭМИЙН СОРИЛ  
БАТАЛГААЖУУЛАЛТЫН УЛСЫН  
ЛАБОРАТОРИ ТӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ  
Ц.ГАНТӨМӨР ТАНАА

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Мал эмнэлэгийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын лаборатори ТӨААТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд, санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол дагуу Мал эмнэлэгийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын лаборатори ТӨААТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Аудитын явцад илэрсэн зөрчлийн талаарх үнэлэлт дүгнэлтийг энэ тайлангийн 2.12-д тусгасан бөгөөд залруулаагүй, алдаа, зөрчлийг материаллаг байдлын түвшинтэй харьцуулахад аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэлтэй байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Мал эмнэлэгийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын лаборатори ТӨААТҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

### **Аудитын гол асуудал**

- Байгууллагын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 2001 онд ашиглалтанд орсон 4.2 сая төгрөгийн анхны өртөгтэй 4.2 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй суудлын автомашин нь биетээр байхгүй байна. Машиныг орлогод авахдаа техникийн болон эзэмшигчийн бичиг баримтыг хувь хүний нэрээр авч, уг машиныг 2007 онд эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр худалдсан;
- Нийт авлагын үлдэгдлээс 4 байгууллагын 9.3 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй;
- Тус байгууллагын захирлаар ажиллаж байсан Д.Ууганбаяр нь байгууллагын хөрөнгөөр худалдан авсан 2.0 сая төгрөгийн үнэ бүхий iPhone гар утсыг байгууллагад тушаагаагүй хувьдаа авсан;
- Төлөгдөх хугацаа нь 1 жилээс дээш хэтэрсэн 6.8 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй; Дээрх зөрчлүүд нь санхүүгийн тайлагналын оршин байх, үнэн зөв байх, иж бүрэн байх, эрх ба үүрэг, батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### **Үүрэг, хариуцлага**

Мал эмнэлэгийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын лаборатори ТӨААТҮГ-ын удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1–д заасны дагуу, тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын болон Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ  
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



## 2 Аудитын тайлан

### 2.1 Оршил

Мал эмнэлэгийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын лаборатори ТӨААТҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг Мал эмнэлэгийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын лаборатори ТӨААТҮГ-ын захирал Ц.Гантөмөр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн жилийн эцсийн санхүүгийн тайлан, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн бараа материалын хадгалалт, шинжилгээний орлогын бүртгэл, эзэмшигчийн өмчийн бүртгэл, анхан шатны баримтын бүрдлийн талаарх зөвлөмжийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

### 2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Мал эмнэлэгийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын лаборатори ТӨААТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Мал эмнэлэгийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын лаборатори ТӨААТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайлан, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /НББОУС/ түүнд нийцүүлэн гаргасан аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Мал эмнэлэгийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын лаборатори ТӨААТҮГ-ын удирдлага жилийн эцсийн санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон СТОУС, НББОУС түүнд нийцүүлэн баталсан аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн жилийн эцсийн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 2 дүгээр сарын 12-ны өдрөөс 2018 оны 3 дугаар сарын 13-ны хооронд хийж, аудитын тайланг 2018 оны 3 дугаар сарын 14-нд эцэслэн баталгаажуулж, Мал эмнэлэгийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын лаборатори ТӨААТҮГ-ын захиралд хүргүүлэхээр төлөвлөн, “Ихмонгол хөлөг Аудит” ХХК-ийн аудитор Д.Пүрэвжаргал, аудиторын туслах Т.Оюун, аудиторын туслах М.Батжаргал нар хариуцаж хэрэгжүүлэв.

Мал эмнэлэгийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын лаборатори ТӨААТҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 2018 оны 2 дугаар сарын 21-ний өдрийн 30 дугаар албан бичгээр 6 хоногоор тайланг хожимдуулан “Ихмонгол хөлөг Аудит” ХХК-д ирүүлсэн байна.



### **2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Мал эмнэлэгийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын лаборатори ТӨААТҮГ нь санхүүгийн үйл ажиллагаандаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хууль, Эм эмнэлэгийн хэрэгслийн тухай хууль, Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай болон бусад холбогдох хуулиуд, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /НББОУС/, Сангийн сайдын 2014 оны 249 дүгээр тушаалаар баталсан “Аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн заавар”, 2012 оны 77 дугаар тушаалаар баталсан “Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар” зэрэг эрх зүйн актуудыг мөрдөж байна.

Мал эмнэлэгийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын лаборатори ТӨААТҮГ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас баталсан гэрээ, зорилтот түвшний үзүүлэлтийг ханган биелүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн, өөрийн орлогоор зардлаа санхүүжүүлэн ажилладаг.

Мал эмнэлэгийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын лаборатори ТӨААТҮГ-ын эрхэм зорилго нь Үндэсний болон олон улсын фармакопейн шаардлага хангасан эм, биобэлдмэлийг хэрэглээнд гаргаснаар малын эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдал, нийтийн эрүүл мэндийг хамгаалахад нарийн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэхэд оршино.

#### **Үйл ажиллагааны стратегийн зорилт:**

Төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлж Монгол улсын мал эмнэлэгийн ажил үйлчилгээг фармакопейн шаардлага хангасан, эм биобэлдмэлээр тасралтгүй хангахад дэмжлэг үзүүлэх, малын эмийн салбарын бодлогыг хэрэгжүүлэхэд нарийн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх, малын эмийн шалгалтанд яанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх хэрэгжүүлэх, шинээр зохион бүтээгдэж байгаа болон нийлүүлэгдэж буй эм, биобэлдмэлийн чанар аюулгүй байдал, стандартын төсөлд санал оруулах зорилттой.

#### **Мал эмнэлэгийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын лаборатори ТӨААТҮГ-ын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл:**


Монгол улсад үйлдвэрлэгдэж импорлогдож, шинээр зохион бүтээгдэж буй мал амвтдын гоц халдаварт, паразиттах болон халдваргүй өвчнөөс урьдчилан мэргийлэх, эмчлэх, оношлох эм биобэлдмэл, эмийн түүхий эдэд хими, биологи, вирусологи, бактерлоги, паразитологийн сорилт шинжилгээ гүйцэтгэж, сорилтын дүн, баталгаажуулалтын дүгнэлт, тохирлын гэрчилгээ олгох үүрэгтэй юм.

Мал эмнэлэгийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын лаборатори ТӨААТҮГ-ын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд төлөвлөсөн хэмжээнд судалж, баримтжуулсан.

### **2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000–1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС, НББОУС, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Мал эмнэлэгийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын лаборатори ТӨААТҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлангийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлж баримтжуулсан.



Жилийн эцсийн санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 11 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 36 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 2.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

Мал эмнэлэгийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын лаборатори ТӨААТҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтний оролцоо шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ.

Мал эмнэлэгийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын лаборатори ТӨААТҮГ нь санхүүгийн тайлангаа өөрийн үйл ажиллагааны онцлогт тохируулсан нягтлан бодох бүртгэлийн “LIDER” програм хангамжаар бэлтгэсэн байна.

## 2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Мал эмнэлэгийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын лаборатори ТӨААТҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт “Хэвийн” гэж үзлээ.

Мал эмнэлэгийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын лаборатори ТӨААТҮГ-ын 2015-2016 оны санхүү эдийн засгийн үзүүлэлтүүдийн биелэлт, өмч хөрөнгийн хадаглалт хамгаалалт, мөнгөн хөрөнгийн зарцуулалт, санхүү аж ахуйн үйл ажиллагаанд хөтлөгдөх анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, байгууллагын авлага өглөгийн байдал, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн хэрэгжилтийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас шалгаж цаашид авах арга хэмжээний талаар 4 зөвлөмж өгч хэрэгжилтийг 2018 оны 1 дүгээр улиралд ТӨБЗГ-т ирүүлэхээр заасан байна.

## 2.6 Орлого, зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Мал эмнэлэгийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын лаборатори ТӨААТҮГ-ын 2017 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2016 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 317 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар 352.0 сая төгрөгийн орлого, 348.1 сая төгрөгийн зардалтай, 3.4 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллахаар баталсан байна.


Мал эмнэлэгийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын лаборатори ТӨААТҮГ нь тайлант онд 423.3 сая төгрөгийн нийт орлого, 485.9 сая төгрөгийн зардалтай, 62.6 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

## 2.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны сайтад байгууллагын тухайн жилийн зорилтот түвшин, гүйцэтгэл, цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, зарлага, санхүүжилт зэрэг нийт 18 мэдээллийг байршуулахаас санхүүгийн тайлан, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, аудитын тайлан дүгнэлт зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлангаас бусад 15 үзүүлэлтийг байршуулсан байна.

## 2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 11 чиглэлээр эрсдэл дотоод хяналт ба хяналт мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 36 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.



Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 2.9-д хураангуйлан тэмдэглэв.

## 2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

### 2.9.1 Зөвлөмжийн талаар

- Байгууллагын бараа материалын агуулах дахь хөрөнгөнд хяналтын тооллого, ажиглалт хийхэд 1993-1997 онд үйлдвэрлэгдсэн, ашиглах хугацаа дууссан 8 төрлийн химийн бодисуудыг, хугацаа дуусаагүй химийн бодисуудын хамт хадгалаж байна.

Шийдвэрлэсэн нь: Бараа материалын ашиглалтын хугацаа дууссан, хадгалалт, ашиглалтыг сайжруулах.

- Шинжилгээний орлогыг, шинжилгээний журнал, нягтлан бодох бүртгэлийн мөнгөн хөрөнгийн болон авлага өглөгийн дэлгэрэнгүй бүртгэлтэй тулгахад 0.8 сая төгрөгөөр зөрүүтэй бүртгэсэн байна.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно" гэж заасныг мөрдөөгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шинжилгээний орлогыг бүрэн, үнэн зөв бүртгэж байх.

- Нийгмийн даатгалын байгууллагад илүү шилжүүлсэн 0.5 сая төгрөгийг бүртгэж тайлагнаагүй нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нийгмийн даатгалын илүү төлөлтийг авлагын данс бүртгэлд тусгаж байх.

- Байгууллагын санхүүгийн байдлын тайлан дахь төрийн өмчийн дүн 1,206.5 сая төгрөг, улсын бүртгэлийн гэрчилгээнд 183.8 сая төгрөгөөр буюу 1,021.8 сая төгрөгийн зөрүүтэй байгаа нь Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.8-д “хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийн тухай мэдээлэл, түүнийг бүртгэсэн он, сар, өдөр” гэж заасныг зөрчсөн байна.


Шийдвэрлэсэн нь: Эрх бүхий байгууллагын шийдвэр гаргуулж хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээнд өөрчлөлтийг тусгах

Сангийн сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2006 оны “Маягт, загвар батлах тухай” 18/03 дугаар хамтарсан тушаалын дөрөвдүгээр хавсралтаар батлагдсан баримтгүйгээр” Г.Уудамсайханд 0.1 сая төгрөгийг нөхөн олговрыг олгосон байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох эрх зүйн актын дагуу анхан шатны баримтын бүрдлийг хангаж гүйлгээ хийх

### 2.9.2 Албан шаардлагын талаар

- Байгууллагын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 2001 онд ашиглалтанд орсон 4.2 сая төгрөгийн анхны өртөгтэй 4.2 сая төгрөгийн хуримтлагдсан өлөдөлтэй бүрдлийн автомашин нь биетээр байхгүй байна. Машиньг орлогод авахдаа техникийн болон





эзэмшигчийн бичиг баримтыг хувь хүний нэрээр авч, уг машиныг 2007 онд эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр Ц.Энхбаярт зарсан байна. Худалдан авагч нь машины үнэнд 0.7 сая төгрөг тушаасан ба 2008 онд уг хүн нас барсан байна. Байгууллага уг асуудлыг шүүхэд шилжүүлсэн боловч машины эзэмшлийн бичиг баримтыг Ц.Энхбаярын нэр дээр авсан тул шийдвэрлэх боломжгүй гэсэн хариуг өгчээ.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 8-д "өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх" гэж заасныг, оршин байх, үнэн зөв байх, толилуулга ба тодруулга, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох байгууллагын шийдвэрээр данс бүртгэлээс хасах албан шаардлага өгөх

- 46.9 сая төгрөгийн авлагын үлдэгдлээс 4 байгууллагын 9.3 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, Нийт авлагаас төлөгдөх хугацаа нь 1 жилээс дээш хугацаатай 6.8 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 8-д "өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх" гэж заасныг, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулах, авлагыг барагдуулах талаар албан шаардлага өгөх

- Нярав Г.Эрдэнэчулуун нь бараа материалын агуулахын бүртгэл хөтөлдөггүй, нягтлан бодогч санхүүгийн програмаас няравын тайланг гаргадаг, анхан шатны баримтууд нь гарын үсэг дутуу, санхүүгийн тамга тэмдгээр баталгаажуагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-д "Аж ахуйн нэгж байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 13-5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно" гэж заасныг мөрдөөгүй байна.


Шийдвэрлэсэн нь: Холбогдох эрх зүйн актын дагуу анхан шатны баримтын иж бүрдлийг хангах, тайлан тооцоог гаргаж хянуулж байх албан шаардлага өгөх

### 2.9.3 Актын талаар

- Тус байгууллагын захирлаар ажиллаж байсан Д.Ууганбаяр нь байгууллагын хөрөнгөөр худалдан авсан 2.0 сая төгрөгийн үнэ бүхий iPhone гар утсыг байгууллагад тушаагаагүй хувьдаа авсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4-д "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллага үрэгдүүлэн дутаасан хөрөнгийн тооцоог түүний өртөг болон зах зээлийн үнийн аль өндрөөр хийнэ" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын данс бүртгэлд байгаа хөрөнгийг хувьдаа авсны үнэ 2.0 сая төгрөгийг нөхөн төлүүлэх, акт тогтоох.



## **2.10 Анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Мал эмнэлэгийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын лаборатори ТӨААТҮГ-ын анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

## **2.11 Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд**

Мал эмнэлэгийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын лаборатори ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар авлага, өглөг, худалдан авах ажиллагааны талаар дахин хянаж үзэх шаардлагатай гэж үзлээ.

## **2.12 Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл**

Мал эмнэлэгийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын лаборатори ТӨААТҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 1,036.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн. Үүнээс:

Материаллаг бус 1,021.7 сая төгрөгийн алдаа, материаллаг 1.4 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгч, 11.5 сая төгрөгийн 3 албан шаардлага, 2.0 сая төгрөгийн акт тогтоов.

## **2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Мал эмнэлэгийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын лаборатори ТӨААТҮГ-ын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар 2 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

## **2.14 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгов.

Мал эмнэлэгийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын лаборатори ТӨААТҮГ-ын материаллаг байдлын суурийг төлөвлөлтийн үе шатанд орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 485.6 сая төгрөгийн 2 хувиар буюу 9.7 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 485.6 сая төгрөгийн 2 хувь буюу 9.7 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж баталгаажууллаа.

## **2.15 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Мал эмнэлэгийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын лаборатори ТӨААТҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Мал эмнэлэгийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын лаборатори ТӨААТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, СТОУС, НББОУС түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж дүгнэн “Хязгаарлалттай” санал дүгнэлт гаргалаа.



### **3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Мал эмнэлэгийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын лаборатори ТӨААТҮГ-ын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан зөвлөмжүүд цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.



**Асуудал 1: Бараа материалын талаар**

**Тэргүүлэх ач холбогдол №1**

**Ажиглалт**

Байгууллагын бараа материалын агуулах дахь хөрөнгөнд хяналтын тооллого, ажиглалт хийхэд 1993-1997 онд үйлдвэрлэгдсэн, ашиглах хугацаа дууссан 8 төрлийн химийн бодисуудыг, хугацаа дуусаагүй химийн бодисуудын хамт хадаглаж байна.

**Зөвлөмж**

Эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагыг хангахгүй тул тусгаарлан хаягжуулж хадаглах, цаашид холбогдох байгууллагуудад уламжлан устгуулах арга хэмжээг авах

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн дотор Үндэсний аудитын газар ирүүлэх

**Эрсдэлүүд**

Эрүүл ахуй, аюулгүй байдалд нөлөөлөх

/ЭҮ,ТТ, ИБ, Х, ҮЗ /

**Төсвийн захирагчийн хариу**

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.



**Асуудал 2: Авлагын талаар**

**Тэргүүлэх ач холбогдол №2**

**Ажиглалт**

Нийгмийн даатгалын байгууллагад илүү шилжүүлсэн 0.5 сая төгрөгийг бүртгэж тайлагнаагүй байна.

**Зөвлөмж**

Нийгмийн даатгалын байгууллагатай тооцоо нийлж, залруулах

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн дотор Үндэсний аудитын газар ирүүлэх

**Эрсдэлүүд**

Хууль тогтоомж, заавар журмыг хэрэгжүүлэхгүй байх

/ЭҮ,ТТ, ИБ, ҮХ, ҮЗ, /

**Төсвийн захирагчийн хариу**

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.



**Асуудал 3: Орлогын талаар**

**Тэргүүлэх ач холбогдол №3**

**Ажиглалт**

Шинжилгээний орлогыг, шинжилгээний журнал, нягтлан бодох бүртгэлийн мөнгөн хөрөнгийн болон авлага өглөгийн дэлгэрэнгүй бүртгэлтэй тулгахад 0.8 сая төгрөгөөр зөрүүтэй бүртгэсэн байна. Энэ нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно" гэж заасныг мөрдөөгүй байна.

**Зөвлөмж**

Сорил, шинжилгээний журналд бүртгэгдсэн ажил бүрийн төлбөрийн тооцоололд тогтмол хяналт шалгалт хийж бай

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн дотор Үндэсний аудитын газар ирүүлэх

**Эрсдэлүүд**

Хууль тогтоомж, заавар журмыг хэрэгжүүлэхгүй байх

/ЭҮ, ТТ, ИБ, ҮХ, ҮЗ, /

**Төсвийн захирагчийн хариу**

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.



**Асуудал 4: Эзэмшигчийн өмчийн талаар**

**Тэргүүлэх ач холбогдол №4**

**Ажиглалт**

Байгууллагын санхүүгийн байдлын тайлан дахь төрийн өмчийн дүн 1,206.5 сая төгрөг, компанийн улсын бүртгэлийн гэрчилгээнд 183.7 сая төгрөгөөр буюу 1,021.7 сая төгрөгөөр зөрүүтэй байна.

**Зөвлөмж**

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт уламжлан шийдвэрлүүлэх.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн дотор Үндэсний аудитын газар ирүүлэх

**Эрсдэлүүд**

Зардал буруу илэрхийлэгдэх, стандарт заавар, журмыг мөрдөхгүй байх.

/ЭҮ,ТТ, ИБ, Х, ҮЗ /

**Төсвийн захирагчийн хариу**

Асуудлын үйлчлүүлэгчийн санхүүгийн ажилтанд танилцуулсан болно. бүртгэлийг удирдлага, танилцуулсан болно.



**Асуудал 4: Анхан шатны баримтын талаар**

**Тэргүүлэх ач холбогдол №5**

**Ажиглалт**

Сангийн сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2006 оны “Маягт, загвар батлах тухай” 18/03 дугаар хамтарсан тушаалын дөрөвдүгээр хавсралтаар батлагдсан баримтгүйгээр” Г.Уудамсайханд 0.1 сая төгрөгийг нөхөн олговрыг олгосон байна.

**Зөвлөмж**

Холбогдох эрх зүйн актын дагуу анхан шатны баримтын бүрдлийг хангаж гүйлгээ хийх

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн дотор Үндэсний аудитын газар ирүүлэх

**Эрсдэлүүд**

Зардал буруу илэрхийлэгдэх, стандарт заавар, журмыг мөрдөхгүй байх.

/ЭҮ,ТТ, ИБ, Х, ҮЗ /

**Төсвийн захирагчийн хариу**

Асуудлын үйлчлүүлэгчийн санхүүгийн ажилтанд танилцуулсан болно. бүртгэлийг удирдлага, танилцуулсан





#### 4 Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, зорилтот түвшний биелэлт

##### 4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	47,225,453.38	54,718,623.63
Дансны авлага	36,280,105.33	46,499,636.00
Татвар, НДШ-ийн авлага	769,932.34	448,494.87
Бусад авлага	-	-
Бараа материал	111,956,005.47	106,454,497.79
Урьдчилж төлсөн зардал /Тооцоо/	-	-
Эргэлтийн хөрөнгийн дүн	196,231,496.52	208,121,252.29
Үндсэн хөрөнгө	724,410,211.76	642,651,959.51
Биет бус хөрөнгө	575,666.62	399,666.62
Бусад эргэлтийн бус хөрөнгө	-	-
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	724,985,878.38	643,051,626.13
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>921,217,374.90</b>	<b>851,172,878.42</b>
Дансны өглөг	15,671,408.80	5,147,124.00
Цалингийн өглөг		214,200.00
Татварын өглөг	576,375.33	2,672,960.32
НДШ өглөг	-	-
Урьдчилж орсон орлого	-	775,200.00
Богино хугацаат өр төлбөрийн дүн	16,247,784.13	8,809,484.32
Урт хугацаат зээл	-	-
Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
Өр төлбөрийн дүн	16,247,784.13	8,809,484.32
Өмч Төрийн	1,206,486,256.88	1,206,486,256.88
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	188,108,836.79	188,108,836.79
Хуримтлагдсан ашиг	(489,625,502.90)	(552,231,699.57)
Эздийн өмчийн дүн	904,969,590.77	842,363,394.09
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>921,217,374.90</b>	<b>851,172,878.42</b>



#### 4.2 Аудит хийгдсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
Борлуулалтын орлого	416,002,485.00	420,119,383.80
Борлуулалтын өртөг		
Нийт ашиг/алдагдал	416,002,485.00	420,119,383.80
Хүүгийн орлого	2,967,326.00	3,214,334.82
Бусад орлого	-	-
Борлуулалт маркетингийн зардал	-	-
Ерөнхий ба удирдлагын зардал	474,408,656.00	482,034,581.83
Санхүүгийн зардал	-	133,300.00
Бусад зардал	14,714,898.00	3,450,600.00
Гадаад валютын ханшийн зөрүүний олз/гарз	-	-
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
Татвар төлөхийн өмнөх ашиг/алдагдал	(70,153,743.00)	(62,284,763.21)
Орлогын албан татвар	296,733.00	321,433.47
Татварын дараах ашиг/алдагдал	(70,450,476.00)	(62,606,196.68)



### 4.3 Аудит хийгдсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

*/төгрөгөөр/*


	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2015 оны 12-р сарын 31- ний үлдэгдэл	1,206,486,256.88	188,108,836.79	(419,175,000.00)	975,420,093.67
Залруулсан үлдэгдэл				-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			(70,450,502.90)	(70,450,502.90)
Өмчид гарсан өөрчлөлт				-
Зарласан ногдол ашиг				-
2016 оны 12 -р сарын 31 - ний үлдэгдэл	1,206,486,256.88	188,108,836.79	(489,625,502.90)	904,969,590.77
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			(62,606,196.68)	(62,606,196.7)
Өмчид гарсан өөрчлөлт				-
Зарласан ногдол ашиг				-
2017 оны 12 -р сарын 31 - ний үлдэгдэл	1,206,486,256.88	188,108,836.79	(552,231,699.58)	842,363,394.09



#### 4.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	/төгрөгөөр/	
	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
Мөнгөн орлогын дүн	404,104,775.29	419,820,153.58
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	384,163,646.68	374,056,224.00
Бусад мөнгөн орлого	19,941,128.61	45,763,929.58
Мөнгөн зарлагын дүн	390,168,582.35	410,593,126.15
Ажиллагчдад төлсөн	167,529,135.03	198,759,052.20
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	42,914,265.11	47,609,942.30
Бараа материал авахад төлсөн	67,779,179.34	71,323,722.04
Ашиглалтын зардалд төлсөн	25,756,732.00	20,719,224.21
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	5,502,500.00	2,947,000.00
Хүүний төлбөрт төлсөн		
Татварын байгууллагад төлсөн	22,884,320.87	19,274,407.40
Даатгалын төлбөрт төлсөн мөнгө	124,830.00	624,740.00
Бусад мөнгөн зарлага	57,677,620.00	49,335,038.00
Үндсэн үйл ажиллагааны цэвэр монгон гүйлгээний дүн	13,936,192.94	9,227,027.43
Мөнгөн орлогын дүн	2,967,325.59	3,716,047.82
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		501,713.00
Хүлээн авсан хүүний орлого	2,967,325.59	3,214,334.82
Мөнгөн зарлагын дүн	749,990.00	5,449,905.00
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө	749,990.00	5,449,905.00
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө	-	-
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	2,217,335.59	(1,733,857.18)
Мөнгөн орлогын дүн	-	-
Зээл, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан мөнгө	-	-
Мөнгөн зарлагын дүн	4,081,460.00	-
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	-
Төлсөн ногдол ашиг	4,081,460.00	-
Бусад	-	-
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(4,081,460.00)	-
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	12,072,068.53	7,493,170.25
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	35,153,384.85	47,225,453.38
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	47,225,453.38	64,718,623.68



#### 4.5 Аудит хийгдсэн зорилтот түвшний биелэлт

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2016 он	2017 он		Зөрүү	
		Зорилт	Биелэлт	Хувь	Дүн
Бүтээгдэхүүн үйлчилгээ					
Улсын захиалгат вакцин, биобэлдмэл	250	230	248	108%	18
Эм түүний түүхий эд /импорт/	419	400	400	100%	-
НИЙТ ОРЛОГО: Үүнээс	416,002.50	352,000.00	423,333.70	120%	71,333.70
Улсын захиалгат вакцин, биобэлдмэл шалгаж баталгаажуулах төлбөр /гэрээт ажил/	202,370.00	177,000.00	213,396.00	121%	36,396.00
Имдорт, дотоодын эм шалгах	171,121.70	175,000.00	206,723.40	118%	31,723.40
Бусад орлого	42,510.80	-	3,214.30	#DIV/0!	3,214.30
Борлуулалтын нийт орлого	416,002.50	352,000.00	423,333.70	120%	71,333.70
Нийт зардал: үүнээс	474,408.70	348,145.90	485,939.90	140%	137,794.00
Удирдлагын зардал	154,424.40	124,514.70	106,906.80	86%	(17,607.90)
Татвар төлөхийн өмнөх ашиг	(58,406.20)	3,854.10	(62,606.20)	-1624%	(66,460.30)
Цэвэр ашиг	(58,406.20)	3,854.10	(62,606.20)	-1624%	(66,460.30)
төрийн өмчийн ногдол ашиг	(14,090.10)	693.80	(12,521.20)	-1805%	(13,215.00)
Борлуулалтын нэг төгрөгт ногдох зардал	1.10	1.00	1.20	120%	0.20
Нийт авлага	36,280.10	42,000.00	46,948.10	112%	4,948.10
Нийт өр төлбөр	16,247.80	12,000.00	8,034.30	67%	(3,965.70)
бусад өглөг	16,247.80	1,500.00	775.20	52%	(724.80)
Хөрөнгө оруулалт		81,639.20	11,996.90	15%	(69,642.30)
Үндсэн хөрөнгийн элэгдэл	122,980.40	124,528.30	93,931.20	75%	(30,597.10)
Нийт ажиллагсдын тоо	26	26	27	104%	1
Нийт цалингийн сан	197,003.80	223,631.20	235,474.50	105%	11,843.30

